


**ТОГТВОРТОЙ
ХӨГЖЛИЙН ТАЙЛАН**

2024



www.statebank.mn



АГУУЛГА

- 1 БИДНИЙ ТУХАЙ
- 2 БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО
- 3 ХАМТЫН АЖИЛЛАГАА, АМЛАЛТУУД
- 4 ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
- 5 ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ БА УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЭРСДЭЛ
- 6 ТАЙЛАГНАЛ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ



Хүндэтгэсэн:

Б.ТЭЛМҮҮН

**ТУЗ-ИЙН ДАРГА,
Сангийн яамны Татварын
бодлогын газрын дарга**

Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигч, харилцагч, бизнесийн хамтрагч, ажилтан Та бүхэнд “Төрийн банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн нэрийн өмнөөс чин сэтгэлийн мэндчилгээ дэвшүүлэн, 2024 оны “ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТАЙЛАН”-гаа танилцуулж байгаадаа баяртай байна.

Төрийн банк нь өмнөх жилүүдэд дэвшүүлсэн дундаж давхаргыг дэмжих эрхэм зорилгоо бататган, Монгол Улсын Засгийн газрын санхүүгийн зуучлагчийн үүргээ үргэлжлүүлэн хүргэхийн зэрэгцээ төрөөс хэрэгжүүлж буй бодлого, зорилтын хүрээнд ногоон хөгжлийг тусгайлан дэмжих чиглэлийн шинэ, шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг олон нийтэд санал болгон, дэмжлэг үзүүлж ажиллахаар эхний шатны арга хэмжээг авч хэрэгжүүлээд байна.

Банкны үйл ажиллагааны үр ашиг, санхүүгийн сахилга батыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ ил тод байдал, сайн засаглалын олон улсын

зарчмуудыг хэрэгжүүлж, уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой эрсдэлийг удирдах, байгальд ээлтэй, тогтвортой санхүүгийн шийдлийг хөгжүүлэхэд бид тууштай зорьж ажиллаж байна.

Тухайлбал, Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулж, ногоон эдийн засгийг дэмжих зорилгоор үнэт цаасны зах зээлд “Ногоон ирээдүй” бондыг амжилттай гарган, хөдөө аж ахуйн чиглэлд хүлэмжийн хийг бууруулах, бэлчээрийн зүй зохистой ашиглалтыг нэмэгдүүлэх зорилготой бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлж байна.

Тогтвортой хөгжилд чиглэсэн ногоон банкны үйл ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлэх чиглэлээр Дэлхийн банк, Азийн хөгжлийн банктэй хамтран ажиллах саналыг хүргүүлж, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Эрчим хүчний яам, Зээлийн батлан даалтын сан болон Тогтвортой санхүүжилтийн холбоо, Монголын ногоон санхүүгийн корпораци зэрэг байгууллагатай “Хамтын ажиллагааны санамж” бичгийг тус тус байгуулж, бодлогын түвшинд хамтран ажиллах чиглэлийг тодорхойлоод байна.

Цаашид Төрийн банк нь тогтвортой хөгжлийн зарчмуудыг үйл ажиллагаандаа тууштай хэрэгжүүлж, хувьцаа эзэмшигч, харилцагч, бизнесийн хамтрагч, ажилтан болон нийгэмд эерэг нөлөө үзүүлэхийн төлөө ажиллах болно.

Та бүхний итгэл, дэмжлэгт гүнээ талархаж, хамтдаа илүү тогтвортой, хариуцлагатай ирээдүйг бүтээхийг хүсэн ерөөе.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ



Хүндэтгэсэн:

Ө.ГАНТӨР

**ТӨРИЙН БАНКНЫ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ**

Эрхэм хүндэт харилцагчид, хамтрагч түншүүд, ажилтнууд Та бүхэнд Төрийн банкны удирдлагын багийн нэрийн өмнөөс чин сэтгэлийн мэндчилгээ дэвшүүлье.

Бидний хувьд 2024 он сорилт, боломж, амжилтаар дүүрэн жил байлаа. Бид нийгмийн хариуцлагатай, байгаль орчинд ээлтэй, засаглалын өндөр түвшинд хүрэх зорилтуудаа хэрэгжүүлж, тогтвортой хөгжлийн чиглэлээр олон чухал алхмыг хийлээ.

Төрийн банкны нийт актив өнгөрсөн оны эцэст 6.2 их наяд төгрөгт хүрч, 2023 оноос 16.0 хувиар өслөө. Мөн нийт зээлийн багцаа 44.1 хувиар өсгөж, 3.4 их наяд төгрөгт, өөрийн хөрөнгийн өгөөжийг 20.2 хувьд хүргэлээ. Банкны ашиг өмнөх жилээс 13.9 хувиар өсөж, 107.9 тэрбум төгрөгөөр хэмжигдэж байна. Энэ бол Төрийн банк хувьцаа эзэмшигчдийнхээ өмнө хүлээсэн үүргээ итгэл төгс биелүүлсний тод илрэл юм.

Төрийн банк нь 2023 оны тавдугаар сард тогтвортой хөгжил, хариуцлагатай бизнесийн туршлагыг дэлхий дахинаа түгээн дэлгэрүүлэх НҮБ-ын Даян дэлхийн гэрээнд нэгдэн орсон. Тиймдээ ч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, бизнесийн аливаа шийдвэр гаргахдаа байгаль орчин, нийгэм, засаглал

(БОНЗ)-ын хүчин зүйлсийг эн тэргүүнд тавьж ажиллалаа. Мөн бид дэлхий нийтийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж явцын тайлан (Communication on Progress)-г анх удаа боловсруулан НҮБ болон олон нийтэд хүргэж ажиллалаа. Санхүүгийн тайлагналын олон улсын шинэ стандартууд болох S1 тогтвортой байдлын тайлагнал, S2 уур амьсгалын тайлагналыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор олон улсын аудитын Эрнст энд Янг байгууллагын тогтвортой байдал хариуцсан багаас зөвлөх үйлчилгээ авч, тайлагнал хэрэгжүүлэхээр бэлтгэл ажил хангасны зэрэгцээ материаллаг байдлын шинжилгээг гүйцэтгэж, замын зураг боловсрууллаа. Улмаар банкны дунд хугацааны стратеги төлөвлөгөө болон бизнес төлөвлөгөөнд тогтвортой хөгжлийн зорилтуудыг тусгаад байна.

Монгол Улсын “Тогтвортой санхүүгийн замын зураг” баримт бичигт 2030 он гэхэд банкны системийн ногоон зээлийн багцыг нийт зээлийн 10 хувьд хүргэх талаар зорилт дэвшүүлсэн байдаг. Төрийн банкны тогтвортой хөгжилд чиглэсэн зээлийн багц 2024 оны эцсийн байдлаар нэмэгдэж, нийт зээлийн 5.1 хувийг бүрдүүлж байгааг дуулгахад таатай байна.

Тогтвортой, ногоон санхүүжилтийн хэмжээг шат дараатай нэмэгдүүлэхийн тулд энэ төрлийн санхүүжилтийн ач холбогдол, байгаль орчин, нийгэмд үзүүлэх эерэг нөлөөллийг таниулах нь нэн чухал. Төрийн банк нь Инкубатор төвөөрөө дамжуулан давхардсан тоогоор 3.2 сая гаруй иргэнд тогтвортой хөгжил, ногоон эдийн засгийн талаарх мэдээ мэдээллийг түгээж, иргэдийн санхүүгийн боловсролд хувь нэмрээ оруулаад байна.

Бид цахим шилжилтийг эрчимжүүлж, харилцагчдадаа илүү хүртээмжтэй, шуурхай, найдвартай үйлчилгээг хүргэхэд онцгойлон анхаарч ажиллалаа. Энэхүү ахиц дэвшил, ололт амжилт нь Төрийн банкны харилцагчид, хувьцаа эзэмшигчдийн итгэл, дэмжлэгт тулгуурласан үр дүн билээ.

Цаашид бид тогтвортой хөгжлийн зарчмуудыг үйл ажиллагааныхаа үндэс болгож, байгаль орчин, нийгэм, эдийн засагт эерэг өөрчлөлт авчрахын төлөө тууштай ажиллах болно.

БИДНИЙ ТУХАЙ

Монгол Улсын банк, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, хадгаламж эзэмшигчид, харилцагчдын эрх ашгийг хамгаалах зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 348 дугаар тогтоол, Сангийн сайдын 2009 оны 259 дугаар тушаалын дагуу 100 хувь төрийн өмчит Төрийн банкиг үүсгэн байгуулахаар шийдвэрлэж, Банкны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэг, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2000 оны 375 дугаар тушаалаар батлагдсан “Банк түүний нэгж байгуулах зөвшөөрлийн журам”-ыг тус тус үндэслэн 2009 оны арваннэгдүгээр сарын 23-ны өдөр байгуулагдсан. “Төрийн банк” ХК нь 16 дахь жилдээ үйл ажиллагаагаа явуулж байна.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн нэгдсэн чуулганаар “Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль” батлагдсантай холбогдуулан хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд “Төрийн банк” ХК системийн нөлөө бүхий банкуудаа түүчээлж, нээлттэй хувьцаат компанийн хэлбэрт шилжсэн. Ингэхдээ Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооны шийдвэрээр Монголын хөрөнгийн биржэд үнэт цаасаа бүртгүүлж, нийт хувьцааны 5.71 хувийг олон нийтэд санал болгон арилжаалсан бөгөөд 25.4 тэрбум төгрөгийг 7,421 хувьцаа эзэмшигчээс амжилттай татан төвлөрүүлж, нээлттэй хувьцаат компани болсон.

“Төрийн банк” ХК Монгол орон даяар 496 салбар нэгжээр дамжуулан, 2.3 сая харилцагчийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн байгаль орчинд ээлтэй, хүний эрхийг дээдэлсэн, нийгмийн хариуцлагатай, ил тод, сайн засаглалтай, ногоон хөгжил, дундаж давхаргыг бойжуулах, дэмжихэд чиглэсэн санхүүгийн цогц үйлчилгээг дэвшилтэт цахим технологи ашиглан тогтвортой, хүртээмжтэй хүргэх тогтолцоог бүрдүүлэх, ногоон хөгжил, дундаж давхаргыг дэмжигч үндэсний тэргүүлэгч банк болох алсын хараатай ажиллаж байна.

“Төрийн банк” ХК 2024 оны байдлаар 6.2 их наяд төгрөгийн хөрөнгөтэй төдийгүй өөрийн хөрөнгийн хүрэлцээ, хөрвөх чадвар, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар зэрэг Монголбанкнаас тогтоосон шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн ханган, зохистой түвшинд барьж ажиллаж байна.

“Төрийн банк” ХК Монголбанкнаас олгосон зөвшөөрлийн дагуу дараах үйл ажиллагааг эрхэлж байна. Үүнд:

- Мөнгөн хадгаламж
- Зээл
- Төлбөр тооцоо
- Гадаад валют худалдан авах, худалдах, хадгалах, хадгалуулах,
- Үнэт металл, эрдэнийн чулуу худалдаж авах, худалдах, хадгалах, хадгалуулах
- Үнэт зүйл хадгалах
- Гадаад төлбөр тооцоо хийх
- Үнэт цаас гаргах, худалдах, худалдах авах
- Гадаад төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэх
- Даатгалын зуучлалын үйлчилгээ
- Эх үүсвэртэй баталгаа, батлан даалт гаргах
- Эх үүсвэргүй баталгаа, батлан даалт гаргах гэх мэт үйлчилгээ багтаж байна.

Бид нэгдмэл байдал, багаар ажиллах чадвар, итгэл, хүндлэл, мэргэжлийн ёс зүйг эрхэмлэн, бүх түвшинд хөгжил дэвшил, урам зоригтой ажиллахыг чухалчилж, үйл ажиллагааны цар хүрээгээ тэлсээр байна.



АЛСЫН ХАРАА

Дундаж давхаргыг дэмжигч,
үндэсний тэргүүлэгч банк байна.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Харилцагчийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн
байгаль орчинд ээлтэй, хүний эрхийг дээдэлсэн, нийгмийн хариуцлагатай,
ил тод, сайн засаглалтай, ногоон хөгжил, дундаж давхаргыг бойжуулах,
дэмжихэд чиглэсэн санхүүгийн цогц үйлчилгээг дэвшилтэт
цахим технологи ашиглан тогтвортой, хүртээмжтэй хүргэх
тогтолцоог бүрдүүлэхэд оршино.

ҮНЭТ ЗҮЙЛС



ИТГЭЛЦЭЛ

Итгэл, Сэтгэл,
Хүндлэл



ХАРИУЦЛАГА

Сахилга бат,
Сайн үр дүн



УР ЧАДВАР

Хүний хөгжил,
Хөгжлийн
түлхүүр



ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ

Шилэн банк

ТӨРИЙН БАНКНЫ ОНЦЛОХ ТООН ҮЗҮҮЛЭЛТ



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

“Төрийн банк” ХК нь байгаль орчин, хүний эрхийг дээдэлсэн бизнесийн үйл ажиллагаа явуулах, тогтвортой санхүүжилтийн хүрээнд хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлт, агаарын бохирдлын нөлөөг багасгахад хувь нэмрээ оруулах, компанийн засаглалыг сайжруулах, санхүүгийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэхэд анхаарч байна. Улмаар Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй Орлогод нийцсэн орон сууц, Чинээлэг малчин, 20 минутын хот, Инновац аялал жуулчлал зэрэг хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжин ажиллахаар зорьж байна.

Хувьцаа эзэмшигчид

“Төрийн банк” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн бүтцийн хувьд 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт хувьцааны 49.26 хувийг Сангийн яам, 45.03 хувийг Хадгаламжийн даатгалын корпораци, 5.71 хувийг олон нийт эзэмшиж байна.

Банкны тухай хууль, Компанийн тухай хуульд заасан нөхцөл, журмын дагуу 2024 онд “Төрийн банк” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 1, ээлжит бус хурлыг 2, нийт 3 удаа хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулав. Үүнд:

- ТУЗ-ийн 2023 оны 12-р сарын 1-ний өдрийн шийдвэрийн дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг эчнээ санал хураалтаар зохион байгуулж, Төрийн банкны дүрэм болон Хяналтын зөвлөлийн журмын нэмэлт, өөрчлөлтийг 2024 оны 2-р сарын 5-нд баталлаа.
- ТУЗ-ийн 2024 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн шийдвэрийн дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 4 дүгээр сарын 29-нд хосолсон хэлбэрээр зохион байгуулж, 2023 оны үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, ногдол ашиг хуваарилалттай холбоотой асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэлээ.
- ТУЗ-ийн 2024 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн шийдвэрийн дагуу тус банкны хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг эчнээ санал хураалтаар явуулж, “Төрийн банк” ХК-ийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцүүлэхээр тогтсоны дагуу эчнээ санал хураалтыг зохион байгуулж, 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр холбогдох шийдвэрийг гаргав.



Төлөөлөн удирдах зөвлөл

“Төрийн банк” ХК-ийн “Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журам”-ыг олон улсад хэрэгжиж буй засаглалын сайн практик, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хууль, Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны албан хаагчийн болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-д тус тус нийцүүлэн шинэчлэн баталж, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

ТУЗ-ийн ээлжит хурал сар бүр тогтмол, шаардлагатай нөхцөлд тухай бүр хуралдаж, банкны зохион байгуулалтын бүтэц, орон тоо, гүйцэтгэх удирдлагыг томилох, банкны дунд хугацааны стратегийг

батлах, зохистой засаглалын болон эрсдэлийн удирдлагын бодлого, бизнес төлөвлөгөө, үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлттэй танилцах, батлах, эрсдэлийн удирдлага, санхүүгийн болон үйл ажиллагааны хяналтыг хэрэгжүүлэх, олон нийтэд нээлттэй хувьцаат компани болох, ТУЗ-ийн тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах зэрэг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж байна.

ТУЗ нь 2024 онд ээлжит болон ээлжит бусаар нийт 18 удаа хуралдахдаа 66 асуудал хэлэлцэн шийдвэрлэж, 15 үүрэг даалгавар, 79 тогтоол тус тус гаргаж, ТУЗ-ийн бүрэн эрх, үүргийг хэрэгжүүлэн ажиллажээ. ТУЗ-ийн хурлын ирц тогтмол 80-аас дээш хувьтай байв. ТУЗ-ийн хурлын тэмдэглэлийг тухай бүр ТУЗ-ийн

нарийн бичгийн дарга хөтөлж, тогтоолын биелэлтийг Гүйцэтгэх удирдлага болон Дотоод аудитын газраас гаргуулан нэгтгэж, ТУЗ-д танилцуулан, хяналт тавин ажиллалаа.

“Төрийн банк” ХК-ийн ТУЗ-ийн даргаар Б.Тэлмүүн, ердийн гишүүдээр Б.Ганбат, Г.Золбоо, Л.Сонор, Х.Пүрэвсүрэн, хараат бус гишүүнээр М.Батжаргал, С.Цэнд-Аюуш, З.Оюунцацрал, Б.Цэвэгжав нар томилогдож, Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон “Төрийн банк ХК-ийн дүрэм”-д заасан ТУЗ-ийн гишүүний бүрэн эрхийг хэрэгжүүлж, банкны үйл ажиллагааны хэвийн тогтвортой байдлыг бүрэн ханган ажиллаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн



ТУЗ-ийн дарга

Б.Тэлмүүн

Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга

МУИС-ийн Олон улсын харилцааны сургуульд олон улсын эдийн засгийн харилцааны бакалавр, СЭЗДС-д санхүүгийн удирдлагын бакалавр, МУИС-ийн Хууль зүйн сургуульд олон улсын эрх зүйн магистр, АНУ-ын Корнеллийн их сургуульд эдийн засаг, санхүүгийн бодлогын чиглэлээр нийтийн удирдлагын магистрын зэргээр тус тус боловсрол эзэмшсэн. 2010-2024 онд Сангийн яаманд Төсвийн бодлого, төлөвлөлтийн газарт мэргэжилтэн, хэлтсийн дарга, газрын дарга, Татварын ерөнхий газрын дэргэдэх Татварын маргаан таслах зөвлөлийн гишүүн, даргаар тус тус ажилласан туршлагатай.

ТУЗ-ийн гишүүд



Б.Ганбат

ТУЗ-ийн гишүүн, Засгийн газрын
Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга

ЗХУ-ын Дотоод явдлын яамны Академийн хууль эрх зүй бакалавр, ИБУИНВУ-ын Коммонвелт хуулийн коллежид хууль эрх зүйн магистрын зэргээр тус тус боловсрол эзэмшсэн. 1995-2024 онд Сангийн яаманд хуулийн зөвлөх, мэргэжилтэн, ахлах мэргэжилтэн, хэлтсийн дарга, Сайдын зөвлөлийн нарийн бичгийн дарга, газрын орлогч дарга, газрын дарга, Монголбанкны Хууль, эрх зүйн газрын захирал, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга, Засгийн газрын хэрэг эрхлэх газарт газрын дарга, Тэргүүн дэд даргаар тус тус ажилласан ажлын туршлагатай. Монгол Улсын гавьяат хуульч.



Г.Золбоо

ТУЗ-ийн гишүүн, Сангийн яамны
Санхүү, төсвийн судалгааны газрын дарга

МУИС-ийн Эдийн засгийн сургуульд банкны эдийн засагчаар бакалавр, ИБУИНВУ-ын Уэльсийн их сургуульд олон улсын бизнесийн менежментийн чиглэлээр боловсрол эзэмшсэн. 2013-2024 оны хооронд Сангийн яаманд зөвлөх, хэлтсийн дарга, газрын даргаар ажилласан туршлагатай.



Л.Сонор

ТУЗ-ийн гишүүн, Сангийн яамны
Санхүүгийн бодлогын газрын дарга

АНУ-ын Такома коммюнити коллежийн бизнесийн удирдлага, АНУ-ын Вашингтоны их сургуулийн санхүү, бизнесийн удирдлагын бакалавр зэргээр боловсрол эзэмшсэн. 2015-2024 онд Сангийн яаманд Санхүүгийн бодлогын газарт зөвлөх, мэргэжилтэн, хэлтсийн дарга, газрын даргаар тус тус ажилласан ажлын туршлагатай.



Л.Пүрэвсүрэн

ТУЗ-ийн гишүүн

МУИС-д нягтлан бодох, эдийн засгийн чиглэлээр магистр, Голланд Улсын Маастрихтийн менежментийн их сургуульд нягтлан бодох, эдийн засгийн менежментийн чиглэлээр тус тус боловсрол эзэмшсэн. 1992-1996 онд СЭЗИС-д багш, тэнхимийн эрхлэгч, 1996-1997 онд "Говь" ХК-д эдийн засгийн хэлтсийн дарга, 1997-1999 онд Төрийн өмчийн хороонд албаны дарга, 1999-2016 онд Сангийн яаманд газрын дарга, Сангийн сайдын зөвлөхөөр ажиллаж байсан ажлын туршлагатай.



М.Батжаргал

ТУЗ-ийн хараат бус гишүүн

Хөдөө аж ахуйн дээд сургуульд эдийн засгийн чиглэлээр бакалавр, эдийн засгийн ухааны магистрын зэргээр боловсрол эзэмшсэн. 1975-1989 онд Улсын банканд эдийн засагч, орлогч дарга, Увс аймгийн арбитр - ерөнхий арбитрч, 1993-2008 онд Монголбанканд газрын захирал, ерөнхий захирал, ахлах ажилтан, ахлах хянан шалгагч, Хяналт шалгалтын хэлтсийн захирал, Дотоод аудитын газрын ахлах хянан шалгагч, аудитын зөвлөхөөр тус тус ажилласан ажлын туршлагатай. Монгол Улсын гавьяат эдийн засагч.



С.Цэнд-Аюуш

ТУЗ-ийн хараат бус гишүүн, Санхүүч

ОХУ-ын Эрхүү хотын Улс ардын аж ахуйн дээд сургуульд санхүүч мэргэжлээр боловсрол эзэмшиж, бакалаврын зэрэг хамгаалсан. 1978-2015 онд Сангийн яаманд Төсвийн бодлого, төлөвлөлтийн газар мэргэжилтэн, ахлах мэргэжилтнээр тус тус ажилласан ажлын туршлагатай. Монгол Улсын гавьяат эдийн засагч.



З.Оюунцацрал

ТУЗ-ийн хараат бус гишүүн

Эдийн засгийн коллежид банк, зээлийн эдийн засагч мэргэжлээр бакалавр, БНСУ-ын Хандонг глобал их сургуулийн бизнесийн удирдлагын магистр, СЭЗИС-ийн удирдахуйн ухааны доктор зэрэгтэй. 1996 оноос өнөөг хүртэл СЭЗИС-д багш,

тэнхимийн эрхлэгч, профессороор ажиллаж байна.



Б.Цэвэгжав

ТУЗ-ийн хараат бус гишүүн

СЭЗИС-ийн банкны удирдлагын бакалавр, МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн бизнесийн удирдлагын магистр зэргээр тус тус боловсрол эзэмшсэн. 2002-2014 онд Капитрон банканд нягтлан бодогч, эдийн засагч, дилер, салбарын захирал, 2014-2015

онд Богд банк байгуулах төсөл, хөрөнгийн удирдлага хариуцсан гишүүн, 2015-2017 онд "Мегамакс групп" ХХК-д санхүү хариуцсан захирал, 2017-2023 онд "Эрдэнэс Монгол" ХХК-д албаны дарга, хэлтсийн дарга, 2022-2023 онд "Багануур" ХК-ийн ТУЗ-ийн дарга, "Эрдэнэс силвер ресурс" ХХК, "Гашуун сухайт авто зам" ХХК, "Метан газ ресурс" ХХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байсан ажлын туршлагатай.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод

Банкны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.6 дахь хэсэг, Монголбанкнаас баталсан "Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам", Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан "Компанийн засаглалын кодекс"-ын дагуу 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 52 дугаар тогтоолоор хороодын бүрэлдэхүүнийг шинэчлэн баталлаа.

ТУЗ-ийн 2023 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 13 дугаар тогтоолоор батлагдсан ТУЗ-ийн дэргэдэх хороодын ажиллах журамд Банкны тухай хууль, Компанийн тухай хууль, Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан "Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам", Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан "Компанийн засаглалын кодекс"-т заасан шаардлагуудыг тусгасан ТУЗ-ийн дэргэдэх хороод Банкны тухай хууль, Банк эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Компанийн тухай хууль, "Төрийн банк" ХК-ийн дүрэм болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад хэм хэмжээг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

ТУЗ-ийн дэргэдэх Хороодын үйл ажиллагааны журамд ТУЗ нь дэргэдээ Аудитын хороо, Эрсдэлийн удирдлагын хороо, Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороотой ажиллахаар тогтоож, шаардлагатай нөхцөлд цаг үеийн шинжтэй болон бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж ажиллах тухай тусгасан.

ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо, Эрсдэлийн удирдлагын хороо, Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороог ТУЗ-ийн хараат бус гишүүд даргалж байна.

Аудитын хороо

ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо банкны нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, ТУЗ-өөс баталсан банкны стратеги төлөвлөгөө, банкны бодлогын хэрэгжилт, банкны үндсэн үйл ажиллагааны явцад хийгдэх гүйцэтгэлийн болон санхүүгийн үйл ажиллагаатай холбогдох асуудал, түүний үнэн бодит байдалд хяналт тавих, банкны дотоод болон хөндлөнгийн аудитын цар хүрээг тодорхойлох, үр ашигтай хамтран ажиллахад дэмжлэг үзүүлэх, хөндлөнгийн болон дотоод аудит, комплайнсын хяналтын хараат бус байдлыг баталгаажуулах, хараат бус байдалд учирч болзошгүй эрсдэл, түүнийг хэрхэн удирдаж байгаа талаарх хэрэгжилтийн үр дүнг хангах үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Аудитын хорооны хурал сар бүр ээлжит болон ээлжит бусаар зохион байгуулагдаж, 2024 онд нийт 14 удаа хуралдахдаа 43 асуудал хэлэлцэн, 41 шийдвэр гарган, 31 үүрэг даалгавар өгч, ТУЗ-ийг шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллээр хангаж, оновчтой шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэн хорооны эрх үүргийг хэрэгжүүлэн ажилласан.

Эрсдэлийн удирдлагын хороо

ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо банкны үйл ажиллагааны чиглэл бүрд үүсэж болох эрсдэлийн түвшнийг тодорхойлох, илрүүлэх, эрсдэлийг бууруулах, арилгахад шаардлагатай арга хэмжээг авах зэргээр эрсдэлийн оновчтой, шуурхай, хараат бус удирдлагыг хэрэгжүүлэх, Банкны тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хянах тогтолцоог бүрдүүлэх, банкны зохистой, чадварлаг, мэргэшсэн эрсдэлийн удирдлага, мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаанд өртөх эрсдэлийг үнэлэх, банкны үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэх тогтолцоог бүрдүүлэх, эрсдэлийг удирдах чиглэлээр ажиллаж байна.

Эрсдэлийн удирдлагын хорооны хурал сар бүр тогтмол зохион байгуулагдаж, 2024 онд нийт 8 удаа хуралдахдаа 28 асуудал хэлэлцэн шийдвэрлэж, 21 шийдвэр гаргаж, 12 үүрэг даалгавар өгч, ТУЗ-ийг шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллээр хангаж, оновчтой шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэн ажилласан байна.

Нэр дэвшүүлэх хороо

ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо нь банкны залгамж халааны бодлогыг тодорхойлох, банкны Хяналтын зөвлөлийн гишүүн, эрх бүхий албан тушаалтанд нэр дэвшүүлэх, сонгон шалгаруулах, гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээний нөхцөлийг боловсруулах, ажлын гүйцэтгэлд үнэлэлт өгөх, банкны эрх бүхий албан тушаалтны мэдлэг, чадвар, ажлын туршлагын талаар дүгнэлт гаргах, ашиг сонирхлын зөрчил үүссэн эсэх, ТУЗ-ийн хараат бус гишүүдийн бие даасан, хараат бус байдлыг тогтоох, тэдгээрийг сургах, мэргэшүүлэх болон хувьцаа эзэмшигчдээс ТУЗ-ийн хараат бус гишүүнийг сонгох, чөлөөлөх зэрэг асуудлаар мэргэжлийн дэмжлэг үзүүлэх чиглэлээр ажиллаж байна.

Нэр дэвшүүлэх хорооны ээлжит хурал улирал бүр тогтмол зохион байгуулагдаж, 2024 онд 8 удаа хуралдахдаа 16 асуудал хэлэлцэн шийдвэрлэсэн байна.

Цалин урамшууллын хороо

ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хороо банкны алсын хараа, онцлогт тохирсон, шударга ил тод, зах зээлд өрсөлдөхүйц нөхцөлийг хангасан, ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуур, банкны ашиг болон ажлын гүйцэтгэлд суурилсан ажилтны нийгмийн баталгааг хангаж, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн цалин урамшууллын бодлогыг тодорхойлоход мэргэжлийн дэмжлэг үзүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.

Цалин урамшууллын хороо 2024 онд 2 удаа хуралдаж 3 асуудал хэлэлцэн шийдвэрлэж хорооны эрх, үүргийг хэрэгжүүлэн ажилласан байна.





БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО



БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

Бид Байгаль орчин, нийгэм, засаглалын бодлогыг олон улсын гэрээ конвенц, Монгол Улсын хууль тогтоомж, холбогдох баримт бичигт нийцүүлэн 2022 онд баталсан. Тус бодлогоор байгаль орчин, нийгэм, засаглалын талаар баримтлах зарчим болон зарчмын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг тодорхойлов.

Байгаль орчны чиглэлд:

Санхүүжилтийн хөшүүргийг ашиглан хүлэмжийн хийн ялгарал болон уур амьсгалын сөрөг үр нөлөөнөөс үүсэх эрсдэлийг багасгах зорилтыг хэрэгжүүлэх



Засаглалын чиглэлд:



Банкны үйл ажиллагаа болон стратеги, бизнес төлөвлөгөөнд байгаль орчны асуудлыг авч үзэх, зохистой байдлын тогтолцоог бүрдүүлэх, түүний хэрэгжилтийг хангах хүрээнд холбогдох мэдээллийг ил тод тайлагнах

Нийгмийн чиглэлд:

Байгаль орчны менежментийг хэрэгжүүлж буй харилцагчдад санхүүжилт олгох, дундаж давхаргын иргэдийн амьдралын чанарыг дэмжих зорилгоор тэдэнд зориулсан бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгох

БАНКНЫ БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ БҮТЭЦ



Төрийн банк нь тогтвортой хөгжлийн засаглалын хувьд илүү бэхжин Тогтвортой хөгжлийн хороо, түүний дэргэд Тогтвортой хөгжлийн алба болон Тогтвортой хөгжлийн ажлын хэсгийг тус онд илүү өргөжүүлэн ажиллалаа. Гүйцэтгэх удирдлагын түвшинд Дэд захирал Тогтвортой хөгжлийн албыг шууд удирдлагаар ханган ажиллаж байна.

Тогтвортой хөгжлийн хороо

Тогтвортой хөгжлийн хороо нь банкны дотоод болон бизнесийн үйл ажиллагаанд хэрэгжүүлэх БОНЗ-ын асуудлууд, бодлогын хэрэгжилт, тогтвортой хөгжилтэй холбоотой эрх зүйн баримт бичгийг хэлэлцэх, тогтвортой хөгжлийн үйл ажиллагааны төсвийн төсөл, жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг хэлэлцэж, банкны бизнес төлөвлөгөөнд тусгуулахаар хүргүүлэх, хэрэгжилтийг хянан жилийн тайланг хэлэлцэж батлах зэрэг чиг үүрэгтэй ажилладаг.

Тогтвортой хөгжлийн хороо 2024 онд нийт 5 удаа хуралдаж, 18 шийдвэр гаргасан бөгөөд чиг үүргийн хүрээнд тогтвортой хөгжлийн чиглэлээр 13 асуудлыг хэлэлцэж шийдвэрлэлээ. Тухайлбал, Тогтвортой санхүүжилтийн хүрээ, сэргээгдэх эрчим хүчний технологийг ашиглах болон Гэр бүлд ээлтэй банк хөтөлбөрийн хэрэгжилт зэрэг асуудлыг хэлэлцэн шийдвэр гаргаж, биелэлтийг нь хангуулж ажиллалаа.

Тогтвортой хөгжлийн албаны чиг үүрэг

Банкны бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтийн хүрээнд “Тогтвортой хөгжлийн алба”-ыг 2023 онд байгуулж, тогтвортой хөгжлийн үйл ажиллагааг банкны бүхий л түвшинд хэрэгжүүлэх зорилготой Тогтвортой хөгжлийн ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг өргөжүүлэн, чиглэл тус бүрд анхаарч ажиллаж байна.

Тогтвортой хөгжлийн алба нь ногоон банкны үйл ажиллагааг хэрэгжүүлэх, байгаль орчин, нийгэм, засаглалын чиглэлээр стратеги, бодлогыг тодорхойлох, ногоон төсөл, хөтөлбөрүүдийг холбогдох төсөл

хэрэгжүүлэгч байгууллагатай хамтран хэрэгжүүлэх, үүнд шаардлагатай эх үүсвэрийг татах, цаашид төр, хувийн хэвшлийн байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлэх үндсэн чиг үүрэгтэй ажиллаж байна.

Түүнчлэн, тогтвортой хөгжилд чиглэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх, олон улсад нэгдэн орсон гэрээ, конвенц, стандартын дагуу үйл ажиллагаа явуулах, хүлэмжийн хийн ялгаруулалт болон уур амьсгалын эрсдэлийг тооцож, тайлагнах, бууруулах зэрэг ажлыг үе шаттай хэрэгжүүлж байна.




 **Тогтвортой
хөгжлийн хороо**

 **Тогтвортой
хөгжлийн журам**

 **Тогтвортой
хөгжлийн алба**

Тогтвортой хөгжлийн түүхэн товчоо



МАТЕРИАЛЛАГ СЭДВҮҮД

Төрийн банк 2024 онд олон улсын зөвлөх үйлчилгээний байгууллагатай хамтран байгаль орчин, нийгэм засаглалын хүрээнд банкны материаллаг/чухал сэдвүүдийг тодорхойллоо.

Материаллаг/чухал сэдэв нь аливаа байгууллагын бизнесийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал болон урт хугацааны тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлөх хүчин зүйлс бөгөөд хөрөнгө оруулалт хийх, шийдвэр гаргахад тухайн хүчин зүйлсийг харгалзан үздэг. Төрийн банкны байгаль орчин, нийгэм, засаглалын чиглэлээрх материаллаг/чухал сэдвийг танилцуулбал:

Байгаль орчин

- Тогтвортой санхүүжилт
- Уур амьсгалын өөрчлөлт
- Нөөцийн зүй зохистой, хариуцлагатай хэрэглээ

Нийгэм

- Хүртээмжтэй бүтээгдэхүүн, үйлчилгээ
- Харилцагчдын сэтгэл ханамж
- Компанийн нийгмийн хариуцлага
- Өртгийн сүлжээний удирдлага
- Инновац, судалгаа шинжилгээ болон хөгжүүлэлт
- Ажилтны оролцоо, хөгжил

Засаглал


- Бизнесийн ёс зүй
- Компанийн засаглал
- Кибер аюулгүй байдал, мэдээллийн аюулгүй байдал
- Эрсдэлийн удирдлага

Материаллаг/чухал сэдвүүдийг тодорхойлохдоо банкны бүхий л оролцогч талуудыг хамрууллаа. Үүнд:

- Харилцагч, хувьцаа эзэмшигч, ТУЗ-ийн гишүүд зэрэг нийт 197 хүнийг хамруулсан судалгаа
- Банкны удирдлага болон ахлах мэргэжилтнүүдийн оролцоотой фокус бүлгийн ярилцлага
- Гадаад болон дотоод 4 оролцогч талыг хамруулсан ганцаарчилсан ярилцлага

Материаллаг/чухал сэдвийг тодорхойлохоос гадна сүүлийн үеийн Global Reporting Initiative (GRI) стандартын дагуу материаллаг байдлын матрицыг давхар боловсруулсан бөгөөд уг стандарт нь байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл (нөлөөллийн материаллаг байдал) болон компанийн санхүүгийн үнэ цэнд байгаль орчны үзүүлэх нөлөөлөл (санхүүгийн материаллаг байдал)-ийг харгалзан үздэг юм.





Замын зураг, S1 S2 зөрүүгийн зөвлөх үйлчилгээний талаар

Оролцогч талуудын санал, материаллаг байдлын үнэлгээ нь банкны тогтвортой байдлын ерөнхий стратегитай нийцэх тогтвортой байдлын чухал сэдвүүдийг тодорхойлох зорилготой бөгөөд тухайн материаллаг сэдвийн хүрээнд замын зургийг боловсруулж, сайжруулах шаардлагатай ажлуудыг 2025-2027 онд хэрэгжүүлэх банкны дунд хугацааны стратеги төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхээр зорьж байна.

Мөн ногоон хөгжилд чиглэсэн үйл ажиллагааг тэлэх зорилгоор Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын Тогтвортой байдлын тодруулгын стандартын дагуу Тогтвортой байдал, Уур амьсгалын эрсдэлийн чиглэлд зөвлөх үйлчилгээний байгууллагаар зөрүүний шинжилгээ хийлгэж, ил тод тайлагнах шаардлагатай мэдээллийг тодорхойлж, тайлагнахаар бэлтгэж байна.





Хамтын ажиллагаа, амлалтууд



ХАМТЫН АЖИЛЛАГАА, АМЛАЛТУУД

■ Гадаад хамтын ажиллагаа

НҮБ-ын Даян дэлхийн гэрээ



НҮБ-ын Даян дэлхийн гэрээ (UN Global Compact) -ний оролцогчоор 2023 онд нэгдсэнээс хойш бид бодлого, шийдвэр гаргалтдаа байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын зарчмуудыг нэвтрүүлж, тогтвортой хөгжлийн зорилгуудтай нийцсэн үйл ажиллагааг шат дараатай хэрэгжүүлж байна. Энэхүү оролцооны хүрээнд бид 2024 онд анх удаа явцын тайлан буюу "Communication on Progress" тайланг албан ёсоор хүргүүлсэн бөгөөд цаашид жил бүр амлалтаа бататган, хэрэгжилтийн ахиц дэвшлийг тогтмол тайлагнахаар зорьж байна. Мөн ажилтнууд, харилцагчид, хөрөнгө оруулагчид, түнш байгууллагууд болон бусад оролцогч талтай харилцан итгэлцэл, урт хугацааны хамтын ажиллагааг бэхжүүлж байна.

Нүүрстөрөгчийн нягтлан бодох бүртгэлийн санхүүгийн түншлэл



Төрийн банк нь уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг олон улсын зорилтыг дэмжиж, Парисын хэлэлцээр болон тогтвортой хөгжлийн зорилтуудтай үйл ажиллагааг уялдуулан, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад чиглэсэн арга хэмжээг шат дараатай хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд 2023 оны 06 дугаар сард Төрийн банк нь Нидерланд Улсын санаачилсан "Нүүрстөрөгчийн нягтлан бодох бүртгэлийн санхүүгийн түншлэл" (Partnership for Carbon Accounting Financials – PCAF)-д Монгол Улсаас тав дахь гишүүн байгууллага болж нэгдсэн. Энэхүү түншлэлийн хүрээнд эзэл, хөрөнгө оруулалттай холбоотой хүлэмжийн хийн ялгарлыг олон улсын аргачлалын дагуу тооцож, гурван жилийн хугацаанд ил тод тайлагнах үүрэг хүлээгээд байна.



Нүүрстөрөгчийн нягтлан бодох бүртгэлийн санхүүгийн түншлэл (PCAF) нь дэлхийн хэмжээний хамтын ажиллагаа бүхий байгууллага бөгөөд санхүүгийн байгууллагуудад зориулан хүлэмжийн хийн ялгарлыг үнэлэх, бүртгэх, тайлагнах нэгдсэн аргачлалыг боловсруулсан. Энэхүү стандартыг нэвтрүүлснээр Төрийн банк нь уур амьсгалын эрсдэлийг үнэлэх, хариуцлагатай тогтвортой санхүүжилт олгох, уур амьсгалд ээлтэй бүтээгдэхүүн, үйлчилгээ хөгжүүлэх, улмаар санхүүгийн урсгалаа Парисын хэлэлцээрийн зорилттой нийцүүлэх боломжийг бүрдүүлнэ.

Мөн банкны дотоод чадавхыг бэхжүүлэх хүрээнд банкны 5 ажилтан PCAF-аас боловсруулсан "Санхүүжүүлсэн хүлэмжийн хийн ялгаруулалтыг тооцох" 7 модуль сургалтад амжилттай хамрагдаж, сертификат авсан. Энэ нь хүлэмжийн хийг дотоод нөөц бололцоондоо тулгуурлан тооцоолох суурь чадавхыг бүрдүүлж, бодит хэмжилт, ил тод байдлыг хангах чухал алхам боллоо.





Тайлант жилд Америкийн Нэгдсэн Улсын “Cargill Financial Services International” байгууллагаас 2 удаагийн хэлцлээр хөдөө аж ахуйг

дэмжих зориулалттай 70.0 сая ам.долларын эх үүсвэр, Нидерландын “Frontclear” байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлж, 31 сая ам.доллартай тэнцэх хэмжээний 105.9 тэрбум төгрөгийн репо эх үүсвэрийг тус тус татан төвлөрүүлээ.



Олон улсын үнэлгээний Moody's агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийг B3-аас B2 болгон сайжруулсантай холбогдуулан


Төрийн банкны үнэлгээг B2/Хэтийн төлөвийг тогтвортой болгож нэг шат ахиуллаа.



Гадаад төлбөр тооцооны СВИФТ системийн “SWIFT essentials” багцын “Payment controls” үйлчилгээг банкны үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүллээ.

■ Дотоод хамтын ажиллагаа

Тогтвортой хөгжилд чиглэсэн ногоон банкны үйл ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлэхээр төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтын ажиллагааг бэхжүүлэх арга хэмжээг авч байна. Тухайлбал, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Эрчим хүчний яам, Зээлийн батлан даалтын сан, Монголын байгалийн өв сан, Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоо, Монголын ногоон санхүүгийн корпорац болон Тогтвортой санхүүжилтийн холбоо ТББ-тай хамтын ажиллагааны санамж бичиг байгуулж, бодлогын түвшинд хамтран ажиллах чиглэлүүдийг тодорхойллоо.



■ “Тэрбум мод” сан

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг дэмжин “Тэрбум мод сан”-д шимтгэлийн орлогоосоо нийт 2,678.2 сая төгрөг төвлөрүүлж дараах төслүүдэд хөрөнгө оруулсан.

- Нийт 31 төрийн өмчит сургууль, цэцэрлэг, эмнэлэг, асрамжийн газрын гадна ногоон байгууламжийн тохижуулалт,
- Нийслэлийн 3 дүүргийн 5 газарт, орон нутгийн 5 бүсэд ойжуулалт, ойн нөхөн сэргээлт,
- Байгаль орчин, экологийн боловсрол олгох хүрээнд томоохон хэмжээний 5 төсөл, хөтөлбөр

“Тэрбум мод сан”-гаас нийт 81 төслийг сонгон шалгаруулж санхүүжилт олгосон бөгөөд санд төвлөрүүлсэн санхүүжилтээс Төрийн банканд хамаарах хэсгийг хувьчилж тооцвол:



218,728 мод,
77.89 га талбайд ойжуулалт,
1,003.41 тн CO₂ хүлэмжийн хийн шингээлт



ТОГТВОРТОЙ
ХӨГЖЛИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГАА



■ Тогтвортой ажлын байр

- Хүний нөөцийн бодлогыг шинэчилж, “Хүний эрх ба жендэр”-ийн бодлогыг шинээр тусган, бизнесийн үйл ажиллагаанд шийдвэр гаргалт болон үйл ажиллагааны бүхий л түвшинд хүний эрх болон жендэрийн эрх тэгш байдлыг хангах, ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд жендэрийн тэгш бус байдлыг бууруулах, ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх тогтолцоог бий болгов.
- Чиг үүрэг, орон тоог зохистой хуваарилах замаар 2024 онд 10 ажлын байрыг шинээр нэмж, 42 орон тоог дотооддоо шилжүүлэн хуваариллаа.
- Шинэ ажилтныг байгууллагын соёл, ажлын орчинд хурдан дасан зохицуулах, дадлагажуулах зорилго бүхий “Дасан зохицох 30-60-90” хөтөлбөрийг системийн хэмжээнд хэрэгжүүлж эхлэв.
- “Байгууллагын дотоод соёл, бүтээмж, ажилтны сэтгэл ханамжийн судалгаа”-г ММСГ байгууллагатай хамтран зохион байгуулж, ажилтны сэтгэл ханамж, сайн сайхан байдлыг нэмэгдүүлэх чиглэлээр төлөвлөгөөт ажлууд хэрэгжүүллээ.
- Хүний нөөцийн гаралтыг өмнөх оноос 7 хувиар бууруулж, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллав.

Жендэрийн эрх тэгш байдал, ажилтнуудын гэр бүлд ээлтэй хөдөлмөр эрхлэлтийн таатай нөхцөл, ажлын уян хатан нөхцөлийг санал болгох, ажилтнуудын ажил амьдралын тэнцвэрийг хангах, олон талт ялгаатай байдлыг дэмжих бодлого, хөтөлбөр хэрэгжүүлж байна.

- Ажилтны ажил амьдралын тэнцвэрийг хангах замаар ажилтны идэвх оролцоо, байгууллага хамт олны үнэ цэнийг нэмэгдүүлж, аз жаргалтай гэр бүл бий болгоход дэмжлэг үзүүлэх “Гэр бүлд ээлтэй банк” хөтөлбөр хэрэгжүүлэв.
- Ажилтнуудад сурч хөгжих боломж олгох, дүрслэх урлагаар дамжуулан хүүхдүүдтэйгээ хамт урлагийн боловсрол эзэмших, төлөвшүүлэх, гэр бүлийн дурсамж бүтээх зорилгоор “Kids Art Festival-2024” хүүхдийн дүрслэх урлагийн наадамд банкны ажилтнуудын 1,000 хүүхдийг эцэг, эхийн хамт оролцууллаа.
- Зайнаас ажиллах боломжтой банкны төв оффисын албан тушаалын жагсаалтыг баталж, ажилтнуудыг зайнаас ажиллуулах болон уян хатан ажлын цагаар ажиллах горим нөхцөлийг хэвшүүлэв.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилтан, өрх толгойлсон болон амьдрах орчин нөхцөл хүнд 5 ажилтанд ажилтны орон сууцны зээлийн эрх олгож, хөнгөлөлттэй нөхцөлтэй орон сууцанд хамруулав. Хөгжлийн бэрхшээлтэй ажилтан болон хөгжлийн бэрхшээлтэй эхнэр, нөхөр, хүүхэдтэй ажилтанд улиралд 1 өдрийн цалинтай чөлөө олгож байна.

Байгууллагын соёлыг төлөвшүүлэх, ажилтнуудыг идэвхжүүлэх, нийгмийн асуудлыг нь шийдвэрлэхэд чиглэсэн төсөл, хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүллээ.

- Баг хамт олны идэвхжүүлэлт, хамтын ажиллагаа, нийгмийн хариуцлага, байгууллагын соёлыг төлөвшүүлэх “Талархлын өдрүүд” аян, “Манлайлагч хамт олон-2024” уралдааныг уламжлал болгон зохион явуулж байна.
- Ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллуулах, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд нь дэмжлэг үзүүлж 200 ажилтанд орон сууцны зээлд хамрагдах эрх олгосон.
- Ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах зорилгоор улсын болон хувийн томоохон эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран ажиллаж, 2516 ажилтныг сонгосон багцаар нь эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамрууллаа.

Ур чадвартай ажилтныг нээн илрүүлж, ажилтнуудын карьер хөгжлийг дэмжих, тасралтгүй сургаж хөгжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэв.

- Ажилтнуудыг чадавхжуулах, хөгжүүлэх, зайнаас суралцах боломжийг бий болгож, нэгжийн ажилтнуудад чиглэсэн сургалтын хүртээмжийг нэмэгдүүлэв. Нийт 168 удаагийн сургалтад 8745 ажилтныг хамруулснаас 68.3 хувь нь цахимаар сургалтад хамрагджээ.
- Банкны залгамж халаа болох ур чадвартай ажилтныг нээн илрүүлэх зорилго бүхий “Талант менежмент 2024” ур чадварын уралдааны ангилалд бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн “Хакатон” тэмцээнийг шинээр нэмж, ур чадвартай ажилтны нөөц санг нэмэгдүүллээ.
- Их, дээд сургуулийн оюутан залууст практикт суурилсан ажлын бодит туршлага хуримтлуулах, ажлын гарааны суурийг цогцоор нь зөв эхлүүлэх боломж олгох зорилгоор Санхүү эдийн засгийн их сургууль, Отгонтэнгэр их сургууль, Хөдөө аж ахуйн их сургууль, Их засаг Олон улсын их сургуультай ажлын байранд суурилсан сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэн 84 оюутныг цалинтай дадлагажуулж, “Ажлын байрны батламж” урилга гардуулав.
- Ажилтнуудыг мэргэшил дээшлүүлэх, мэргэжил эзэмшихэд нь дэмжлэг үзүүлж 20 ажилтанд сургалтын төлбөрийг хөнгөлөв.

■ Сургалт


Байгальд ээлтэй, нийгмийн хариуцлагатай, зохистой засаглал бүхий банк байх зорилтоо хэрэгжүүлэх, хүлэмжийн хийн тооцоолол хийх, ногоон ажлын байр, зохистой орчин бий болгох ажлын хүрээнд гадны байгууллагуудын сургалтад хамрагдлаа.

- Тогтвортой хөгжлийн чиглэлээр 41 удаагийн 17,918 цагийн сургалтыг танхим болон цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулж, 2372 ажилтныг хамруулав.
- Тогтвортой санхүүжилтийн холбоотой хамтран 7 модуль хичээл 32 бүлэг сэдэв бүхий цахим сургагч багш бэлтгэх сургалтад банкны төвийн 22 ажилтныг хамруулж, тогтвортой хөгжлийн сургагч багшаар бэлтгэв.
- Тогтвортой хөгжилд чиглэсэн зээлийн бүтээгдэхүүний нийт зээлийн багцад эзлэх хувийг нэмэгдүүлэх зорилгоор Эрчим хүчний аудитын холбоотой хамтран “Барилгын эрчим хүчний хэмнэлт, гэрчилгээжүүлэлтийн тухай” сургалтад Улаанбаатар хотын нэгжийн ажилтнуудыг хамруулав.
- Обзерв консалтинг байгууллагатай хамтран “Байгаль орчин нийгэм засаглал”-ын мэргэшүүлэх сургалтад банкны төвийн 25 мэргэжилтэн оролцсон.
- PCAF академитай хамтран зохион байгуулсан “Банкны олгосон зээл, санхүүжилт, хөрөнгө оруулалтын хүлэмжийн хийн ялгарал тооцох” 9 модуль сургалтад банкны төвийн 5 ажилтан хамрагдсан.
- “Тогтвортой хөгжил”-д чиглэсэн 6 багц видео хичээлийг анхан ба дунд шатны хэлбэрээр бэлтгэж, сургалтын нэгдсэн программд нээлттэй байршууллаа.
- “Хогоо зөв ангилцгаая” сэдэвт аяныг зохион байгуулж, хогоо зөв ангилах талаар видео контент бэлтгэн, дотоод мэдээллийн систем, сургалтын нэгдсэн программаар нийт ажилтанд түгээсэн.



Хүний эрх, жендэрийн эрх тэгш байдлын талаарх ажилтнуудын мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэв.

- “Компанийн үйл ажиллагаанаас үүдэн хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох, хариуцан арилгах, үр нөлөөтэй шийдвэрлэх нь” сургалтыг зохион байгуулав.
- PwC Mongolia аудитын байгууллагын “Бизнес ба хүний эрх” сургалтад банкны ТУЗ, гүйцэтгэх удирдлагын түвшний нийт 22 төлөөллийг хамруулсан.
- Банкны дотоод нөөц ажилтан бэлтгэх, чадваржуулах сургалтын хөтөлбөрт “ТоС ба БОНЗ-ын тухай ерөнхий ойлголт”, “Жендэрийн тухай ерөнхий ойлголт” сэдвийг багтааж, нийт 35 удаагийн танхимын сургалтад 1008 ажилтныг хамруулсан.
- Банкны сургалтын нэгдсэн программд Жендэрийн тэгш байдлыг хангах, тэгш байдлын тухай болон хэрэгжүүлэх ач холбогдлын талаарх сургалтуудыг цахим хэлбэрээр байршуулж, 706 ажилтан хамрагдсан.
- “Жендэрийн эрх тэгш байдал”-ын тухай мэдлэг олгох банкны сургагч багшийн нөөцийг бэлтгэх зорилгоор банкны төвийн 27 ажилтныг цахим, болон танхимын сургалтад хамруулж, жендэрийн сургагч багшаар бэлтгэлээ.
- НҮБ-ын Даян дэлхийн гэрээний академийн “Жендэр ба тэгш эрх” цахим сургалтад Тогтвортой хөгжлийн ажлын хэсгийн 12 ажилтан хамрагдсан.
- “Хүүхэд асрах чөлөөтэй ажилтан”-ыг чадваржуулах сургалтын хөтөлбөрийг шинээр боловсруулж, хүүхдээ асрах үеийн сэтгэлзүйг дэмжих, хүүхдийн сэтгэлзүй, асаргааны мэдлэг олгох сургалтыг зохион байгуулж, 3-14 насны хүүхэдтэй 50 ажилтан оролцов.
- Хүүхэд асрах чөлөөтэй болон 0-5 насны хүүхэдтэй бөгөөд биечлэн, зайнаас ажиллаж байгаа ажилтнуудад зориулан мэргэжлийн сэтгэл зүйч, хүүхдийн их эмч нарын зөвлөгөө мэдээлэл өгөх, тулгамдаж байгаа асуудлаар харилцан ярилцах, зорилгоор онол, дадлага хосолсон сургалтыг танхим, цахим хэлбэрээр зохион байгуулж 116 ажилтныг хамруулав.
- “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд туслах” ТББ-тай хамтран хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй ажиллах арга зүйн анхан болон дунд шатны чадваржуулах сургалтыг зохион байгуулсан.



■ Мэдээллийн аюулгүй байдал

Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны олон улсын ISO/IEC27001:2022 стандартыг нэвтрүүлж, гүйцэтгэлийг нь олон улсын аудитын байгууллагаар баталгаажуулснаар, Монгол Улсын үндэсний итгэмжлэлийн төв болон олон улсын эрх бүхий байгууллагаас стандарт хангасан сертификатаа хүлээж авлаа. Энэхүү үйл ажиллагаа нь банк харилцагчдынхаа мэдээллийн аюулгүй байдлыг хангах дотоод процесс, соёлыг төлөвшүүлж урт хугацааны тогтвортой хөгжлийг хангахад чухал алхам боллоо.

Төрийн банк 2024 онд мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлд шаардлагатай хөрөнгө оруулалт хийж, кибер аюулгүй байдлын хамгаалалтаа сайжруулсан бөгөөд дараах онцлох системүүдийг амжилттай нэвтрүүллээ.

- Сүлжээний аюулгүй байдлыг сайжруулах чиглэлд шинэ үеийн галт хана (NGFW) шийдлийг амжилттай нэвтрүүллээ. Уг системийн кластер бүтэц нь банкны онц чухал дэд бүтцэд найдвартай байдлыг хангах илүү үр ашигтай бөгөөд аюулгүй байдлыг бий болгосон.
- Цахим шуудангийн аюулгүй байдлыг хангах зорилгоор үүлэн технологид суурилсан хамгаалалтын шийдлийг амжилттай нэвтрүүллээ. Энэ нь цахим шуудангийн системд чиглэсэн халдлага, аюулаас хамгаалах дэлхийд тэргүүлэгч шийдэл юм.



■ Цахим шилжилт



Гялсбанкны үйлчилгээний хуучин хувилбарыг зогсоож, Гялсбанк 3.0 шинэ хувилбар, шинэ хөгжүүлэлт, нэмэлт сайжруулалтын ажлуудыг хийж үндсэн орчинд бүрэн нэвтрүүллээ. Үүнд:

- "HAPPY" хадгаламж
- Цахим кредит карт
- Шуурхай бизнесийн зээлийн эрхийг цахимаар ашиглах
- Нэмэлт цалингийн зээл олголт
- Нэмэлт тэтгэврийн зээл олголт
- Ахуйн хэрэглээний цахим зээл
- "Хайпэймент солюшн" ХХК-тай хамтран Гялсбанк аппликэйшнээр Хайпэй мерчантын QR кодыг таниулах
- Хувийн санхүү модуль сайжруулалт
- Дансны тодорхойлолтыг Гялсбанк 3.0 аппликэйшн, вэб хувилбараар авах

БҮТЭЭГДЭХҮҮН ХӨГЖҮҮЛЭЛТ



Цахимаар олгож буй зээлийн гэрээг тоон гарын үсгээр автоматаар баталгаажуулах төхөөрөмжийг ашиглаж эхэллээ. Ингэснээр цахим зээлийг 100 хувь автоматаар шийдвэрлэж, зээл олгох хугацааг 5 минутаас хэтрэхгүй болгож, харилцагчдад 24/7 зарчмаар зээл авах боломжийг бүрдүүллээ.



Арилжаа хийх боломжтой "Цахим хадгаламжийн сертификат"-ыг шинээр зах зээлд нэвтрүүлж, "Мони маркет фанд" ХХК-ийн бирж дээр байршууллаа.



Олон улсын "Эрүүл иргэн виза карт", "Энгийн виза карт", "Алтан виза карт"-ын босоо загварыг зах зээлд нэвтрүүлсэн. Банкны 15 жилийн ойн хүрээнд олон улсын "Энгийн карт", "Миний Монгол виза карт", дотоодын энгийн "Т карт"-ын загварыг шинэчлэн, шинээр гаргалаа. Эдгээр карт нь босоо загвартай бөгөөд картны дугаар нь график байдлаар хэвлэгдсэн.



Зээлийн хүсэлтийг хүлээж авахаас эхлээд төлөгдөж дуусах хүртэлх үйл ажиллагааг цогц байдлаар зохицуулдаг “Зээлийн нэгдсэн программ”-ыг хөгжүүлж банкны зээлийн үйл ажиллагаанд нэвтрүүлсэн. Тус программ нь зээлийн үйл ажиллагаанд бүх шатны хяналтыг хэрэгжүүлэх, рейтинг, скорингийн үнэлгээний аргачлалаар зээл олгохоос өмнөх эрсдэлийг үнэлэх боломжуудыг нэмэгдүүлэхээс гадна зээлийн судалгаанд зарцуулах хугацаа болон цаасны хэрэглээг бууруулах давуу талтай.



Бизнесийн үйл ажиллагааны дотоод процессыг сайжруулах, түүнд зарцуулах цаг хугацаа, үр ашиггүй зардлыг бууруулах үүднээс ERP систем хөгжүүлэлтийн “Гэрээний удирдлагын нэгдсэн систем”-ийг хөгжүүлэх төслийг хэрэгжүүлж нэвтрүүлсэн. Ингэснээр гуравдагч этгээдтэй хийх гэрээ хэлцлийн төсөл боловсруулах, бусад оролцогч талуудаас санал авах, хянаж, баталгаажуулах процесс цахимжиж, түүнд зарцуулдаг цаг хугацааг хэмнэх, цаасны хэрэглээг бууруулах зэрэг үнэ цэнийг бий болгож байна.



Банкны вэбсайтыг шинэчилж орон сууцны зээлийн хүсэлтийг цахимаар авах, Хаус хадгаламжийн бүтээгдэхүүн үйлчилгээг цахимаар авах, Малчны зээлийн хугацаа сунгах хүсэлтийг хүлээн авах, зээлийг сунгах, Хоршооны гишүүн малчны зээлийн хүсэлтийг бүртгэх тайлагнах боломжтой болов. Мөн ПОС-ын хүсэлтийг цахимаар авах, Шүгэл үлээх системийн хөгжүүлэлтийг гүйцэтгэв.



Киоск төхөөрөмжийн программыг технологийн хувьд бүрэн шинэчилж, Киоск 2.0 хувилбарыг шинэ дизайн өнгө төрхтэйгөөр зах зээлд нэвтрүүлсэн. Киоск 2.0 хувилбар нь төхөөрөмжөөс дансны хуулга авах, Мессеж мэдээ үйлчилгээнд бүртгүүлэх, Автомат хуримтлалын үйлчилгээнд бүртгүүлэх, Дансны тодорхойлолт авах, ПОС төхөөрөмжтэй холбогдох, захиалгат шилжүүлэг, хувийн дугаар авах зэрэг боломжийг агуулсан. Мөн EMV contactless карт унших боломжтой болж цаасан баримтын хэрэглээг бууруулж мессеж, утасны дугаараар баримт авах боломжтойгоор ногоон банкны функцуудыг тусгасан.



Төрийн банкны “ERP” системийг хөгжүүлэх ажлын хүрээнд гэрээний удирдлагын нэгдсэн программ, эрх зүйн баримт бичгийн модуль, сургалт удирдлагын систем, албан томилолт, танилцуулах хуудас, зардал батлуулах үйл ажиллагааг цахимжуулах ажлыг хийж гүйцэтгэв.



БИГ Дата нийлүүлэх ажлын хүрээнд NES системийн харилцагч, харилцах, хугацаагүй хадгаламж, хугацаатай хадгаламж, зээл, кредит карт, барьцаа хөрөнгийн дансны бүртгэлийг цэгцлэх ажлын хэсгийг байгуулан, өөрчлөлтийг баазын түвшинд хийж, бизнес нэгжүүдэд мэдээллийг хүргүүлж, холбоотой тайлангуудад өөрчлөлтийг оруулав.



NES системд динамик категори модулийг нэвтрүүлсэн. Энэ модулийг нэвтрүүлснээр Монгол Улсын Тогтвортой байдлын зөвлөлөөс 2019 онд батлагдсан “Монгол Улсын Ногоон Таксаноми”-ын дагуу олгосон зээлийн санхүүжилтийг ангилан Монголбанканд тайлагнах нөхцөл бүрдэв.

■ Ногоон оффис

Төрийн банкны ногоон хөгжлийг дэмжих чиг үүргээр тусгайлан зохион байгуулсантай холбогдуулан бид байгууллагын соёлдоо ногоон орчныг нэвтрүүлэх, эрчим хүч, ус, цаас зэрэг нөөцийг зохистой ашиглах, хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх, хэмнэх зэрэг ногоон хэрэглээг ажилтнууддаа хэвшүүлэх зорилготой “Ногоон оффисын заавар”-ыг баталлаа.



Тайлант хугацаанд хэрэгжүүлсэн ажлууд:

- Ажлын байранд тогтвортой байдлын соёлыг төлөвшүүлэх, мэдлэг дээшлүүлэх зорилгоор нийт ажилтнуудын дунд “Ногоон оффис зохистой дадал” аяныг зохион байгууллаа. Аянд банкны нийт газар, хэлтэс, албад хамрагдсан бөгөөд аянд түрүүлсэн газрын санаачилгаар “Машингүй өдөр” ажиллагааг сар бүр хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.
- Худалдан авах ажиллагаанд ногоон шалгуурыг тусгаж эхэллээ.
- Банкны хэрэглээнд 10 цахилгаан автомашин худалдан авч, бензин, дизель зэрэг түлшний хэрэглээг буурууллаа.
- Хүлэмжийн хийг бууруулах зорилгоор ажилтнуудад зориулсан нийтийн тээврийн хэрэгслийг ашиглаж эхэлсэн.
- Ажилтнууддаа зайнаас ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн.
- Банкны төв оффист эрчим хүчний хэмнэлтийн горимоор ажилладаг гэрэлтүүлэг болон усны төхөөрөмж суурилууллаа.
- Устгалд оруулах актлагдсан хөрөнгийг ашиглах боломжоор нь ангилав. Төмрийн хаягдлыг тушааж, модны хаягдлыг түлээ, түлш шаардлагатай ажилтнуудад хандивлан хог хаягдлыг буурууллаа.
- 250 кг хуванцар хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлсэн.

■ Хүлэмжийн хийн ялгарал

Төрийн банк 2022 онд өөрийн үйл ажиллагаанаас үүсэх хүлэмжийн хийн (GHG) ялгарлыг Хүрээ 1 болон 2-ын түвшинд анх удаа тооцоолж, хэмжилтийг нь мэргэжлийн зөвлөх үйлчилгээний байгууллагаар гүйцэтгүүлсэн. Харин 2023 оноос банк дотоод чадавхдаа тулгуурлан олон улсын болон үндэсний аргачлалыг хослуулан ашиглаж, хүлэмжийн хийн тооцооллыг хийлээ. Тухайлбал, ISO 14064-1:2018 стандарт, Хүлэмжийн хийн нягтлан бодох бүртгэлийн олон улсын тайлагналын стандарт, Эрчим хүчний зохицуулах хорооны баталсан "Эрчим хүчний салбарын хүлэмжийн хийн ялгарлыг хэмжих, тайлагнах, баталгаажуулах аргачлал"-ыг ашиглав.

Санхүүжүүлсэн хүлэмжийн хийн ялгаруулалтын тооцооллыг гүйцэтгэхдээ 2024 оны зээл болон хөрөнгө оруулалтын хүрээнд PCAF-ын стандартыг баримталж, зориулалт нь тодорхой зээл, санхүүжилтийг хамруулан тооцлоо.



Хамрах хүрээ 1: 680.8 тонн CO₂
Хамрах хүрээ 2: 12,091.3 тонн CO₂
Хамрах хүрээ 3 - 105,105.7 тонн CO₂



Худалдан авалт болон
ажилтнуудын зорчих хөдөлгөөн:
3,642.7 тонн CO₂



Хөрөнгө оруулалт буюу
зээл, санхүүжилт:
101,463.0 тонн CO₂

Хүлэмжийн хийн шингээлт:
1,094.2 тонн CO₂

Цэвэр ялгаруулалт:
116,783.6 тонн CO₂

Хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулах арга хэмжээ

Төрийн банк 2024 онд хүлэмжийн хийн ялгаруулалтаа бууруулах чиглэлд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн бөгөөд ХХЯ-ыг нийт 877.87 тонн CO₂-оор бууруулав. Үүнд:

- **Цахим үйлчилгээ:** 2024 онд цахимаар зээл олголтын гүйлгээ 1,085,823, биллингийн гүйлгээ 3,506,390, бусад гүйлгээ 160,082,174 удаа хийгдсэн. Үр дүн нь нийт 190,734,139 ширхэг цаасыг хэмнэж, ХХЯ-ыг нийт 858.3 тонн CO₂-оор бууруулсан.
- **Цахилгаан машин:** Банкны төвийн үйл ажиллагаанд бензин, дизель ашигладаг 10 тээврийн хэрэгслийг 2024 оны 04 дүгээр сараас эхлэн цахилгаан тээврийн хэрэгслээр сольсноор түлшний хэрэглээ болон ХХЯ-ыг 15.52 тонн CO₂-р бууруулсан.
- **Ажилтнуудын тээврийн хэрэгсэл:** Банкны төвийн ажилтнуудад зориулсан 2 нийтийн тээврийн хэрэгслийг 2024 оны 09 дүгээр сарын 17-ны өдрөөс эхлэн Улаанбаатар хотын 2 чиглэлд явуулж эхэлснээр ажилтнуудын зорчих хөдөлгөөний ХХЯ-ыг 3.0 тонн CO₂-оор бууруулав.
- **Зайнаас ажиллах боломж:** 2024 онд нийт 29 ажилтан 1723 өдрийн хугацаанд зайнаас ажилласан бөгөөд энэ нь ажилтнуудын зорчих хөдөлгөөн болон ХХЯ-ыг 1.05 тонн CO₂-оор бууруулах ач холбогдолтой байсан.
- **Хөдөлгөөн мэдэрч асдаг төхөөрөмж:** Банкны төв оффисуудын үүдний гэрэлтүүлгийг өөрчилж, цахилгааны хэрэглээг бууруулсан.



■ Худалдан авалтын бодлого

2024 онд Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны журамдаа ногоон худалдан авалтын талаарх зохицуулалтыг тусгаж, худалдан авах үйл ажиллагаанд ногоон шалгуурыг тусгав. Түүнчлэн тайлант хугацаанд нийт худалдан авалтын 94.1 хувийг дотоодын бэлтгэн нийлүүлэгчид бүрдүүлсэн байна.

- Банкны хэрэгцээний 10 цахилгаан автомашин
- Бараа, бүтээгдэхүүний хувьд 21 худалдан авалтыг эрчим хүчний хэмнэлттэй буюу А+, дахин боловсруулсан түүхий эдээр хийсэн барааг худалдаж авсан.
- Барилга угсралтын 11, барилга засварын 35, нийт 46 ажлын хүрээнд хүний эрүүл мэнд болон байгаль орчинд сөрөг нөлөөгүй, стандартын шаардлага хангасан барилгын материал буюу ногоон худалдан авалтын шалгуурыг тусгасан худалдан авалтыг зохион байгууллаа.

■ Харилцагчийн үйлчилгээ

Харилцагчийн мэдээллийн төв нь 2024 онд 1800-1881 тусгай дугаарт хандсан харилцагчийн нийт асуудлын 97.9 хувийг эхний хандалтаар шийдвэрлэсэн ба 2.1 хувийн санал, хүсэлт, гомдлыг бүртгэн, холбогдох газар, хэлтэс, алба, салбар, нэгжид илгээн 99.4 хувийг хугацаанд нь шийдвэрлүүлсэн.



Харилцагчийн гүйлгээнд эзлэх цахим гүйлгээний хувь, дижитал банкны үйлчилгээ авч буй харилцагчийн хувь

Харилцагчийн гүйлгээнд
эзлэх цахим гүйлгээний хувь

 **90%**

Дижитал банкны үйлчилгээ авч
буй харилцагчийн эзлэх хувь

 **42.5%**



Олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаа



- Байгаль орчноо хамгаалах үйлсэд олон нийтийг уриалж, нийгэмд эерэг хандлага түгээх зорилготой “Байгальд ээлтэй Гялс цэвэрлэгээ” аяныг долоо дахь жилдээ зохион байгууллаа. Аянд 21 аймаг, 330 сумын гол горхи, ундны усны сав газар, Улаанбаатар хотын Туул гол, Сэлбэ голын сав газар орчмын нийт 7000 гаруй га газрыг цэвэрлэж, 800 гаруй тонн жинтэй, 425 орчим автомашин хог хаягдлыг цуглуулж хаялаа.




- Төр, хувийн хэвшил, иргэдийн уялдаа холбоог сайжруулах замаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгэм, эдийн засгийн бүхий л салбарт хувь нэмрээ оруулан хөгжих орчныг бүрдүүлэх, тэдний нийгмийн оролцоо, хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх зорилгоор “ABILITY EXPO 2024” арга хэмжээнд оролцож, 800 гаруй иргэнд мэдээлэл зөвлөгөө өгсөн.



- “Төрийн банк-15 жил” ойн арга хэмжээг угтан “15 сайн ажил”-ыг санаачилж, энэ хүрээнд ногоон хөгжлийг дэмжих, Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулах зорилгоор унадаг дугуйтай харилцагчийг банкны салбараар үйлчлүүлэх боломжийг нэмэгдүүлэх үүднээс банкны төв оффис, салбар нэгжийн гадна талбайн 15 байршилд дугуйн зогсоол байршуулав.



- Банкны ажилтнуудын дунд “Модыг Мод(а) болгоё-Ажилтан бүр нэг мод” аяныг 2024 онд хоёр удаа зохион байгуулж, Төрийн банкны нийт газар, хэлтэс, алба, салбар, нэгжүүд тус аяны хүрээнд нийт 34 нэр төрлийн 5,594 ширхэг мод тарьж, ногоон байгалийг цогцлооход идэвхтэй хувь нэмэр орууллаа.



- 12,484 ширхэг Эко карт борлуулж, 42.4 сая төгрөгийг ховор амьтдыг хамгаалах “Хүрээлэн төсөл”-д зориулан төвлөрүүлэв.



- Төрийн банк, Амины орон сууцны инновац хөгжлийн төвтэй хамтран байгальд ээлтэй дэвшилтэт технологийг нэвтрүүлж буй бизнес эрхлэгчдийн бүтээгдэхүүн үйлчилгээг иргэд, харилцагчдад таниулах, бизнесийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, хүрээлэн буй орчинд ээлтэй худалдан авалтыг дэмжих зорилгоор “Тогтвортой хөгжил -Ногоон ирээдүй” үзэсгэлэн худалдааг зохион байгууллаа.

ТоС форум



Тогтвортой санхүүжилтийн холбооноос “Монголын тогтвортой санхүүгийн форум-2024” өндөр түвшний бодлогын хэлэлцүүлгийг 2024 оны 11 дүгээр сарын 27, 28, 29-ний өдрүүдэд зохион байгуулсан бөгөөд Төрийн банк тус форумын “Ногоон ирээдүйг цогцлоох эрчим хүчний хэмнэлтийн шийдлүүдийн санхүүжилт” хэсгийг хамтран зохион байгуулж, форумд оролцогч олон улсын болон дотоодын бодлого боловсруулагч, түншүүдэд мэдээлэл түгээв.



■ Санхүүгийн хүртээмж, санхүүгийн боловсрол

Санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд

- Банкны Инкубатор төв болон хамтран ажиллагч байгууллагуудаар дамжуулан бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдэд бизнесийн үйл ажиллагаа, санхүүгээ амжилттай удирдахад хэрэгцээт мэдлэг олгох, тэдний санхүүгийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор нийт 32,535 бизнес эрхлэгчийг хамруулсан сургалт зохион байгууллаа.
- Банкнаас олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, цахим сувгаар дамжуулан 709,733 иргэнд санхүүгийн боловсрол олгох мэдээ, мэдээлэл хүргэсэн.
- Монгол Улсын ирээдүй болсон хүүхэд багачууд, залуусын санхүүгийн боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх, ирээдүйн банкны харилцагч дундаж давхаргын иргэдийг бэлтгэх, хуримтлал бий болгох дадал зуршил олгох зорилгоор ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, их дээд сургуулийн суралцагчдад зориулсан “Санхүүч тагтаа” хөтөлбөрийг боловсруулж, Улаанбаатар орон нутгийн бүх салбар, тооцооны төвүүдээр дамжуулан хэрэгжүүллээ. Хөтөлбөрийн хүрээнд 216,433 оюутан, сурагчдад сургалт зохион байгуулав.

Санхүүгийн боловсрол, зөвлөгөө мэдээлэл



Брэнд реклам

2.6 сая иргэнд мэдээлэл хүргэлээ



26 цуврал видео контент

Бизнес эрхлэгчдийг оролцуулсан “Амжилтын түүх” 26 цуврал контентийг социал сувгаар 2,5 сая иргэнд хүргэсэн.



“Харилцагчийн өдөрлөг-2024” арга хэмжээ

ХАРИЛЦАГЧИЙН
ӨДӨРЛӨГ
2024



- Улаанбаатар - 2 дүүрэг
- Орон нутаг-10 аймаг



32,535

Бизнес эрхлэгч



216,433

Оюутан, сурагч



Давхардсан тоогоор 3.2 сая гаруй иргэнд Санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгсөн.

Сургалт

- Бизнесийг удирдах арга
- Манлайлагчийн ур чадвар
- Брэндинг болон маркетинг
- Орлого зардлын бүртгэл
- Банкны бүтээгдэхүүн үйлчилгээ
- Бизнес төлөвлөгөө боловсруулах
- Эрсдэлийн удирдлага
- Санхүүгийн удирдлага



Олгосон зээл

713 харилцагч

36.3 тэрбум төгрөг



Хамтын ажиллагаа 5 байгууллага

ЖДҮГ, МУХАҮТ, Бэст хөтөлбөр, СЭЗИС, Эрүүл амьдралын жигүүр ТББ



Тогтвортой санхүүжилт



■ Ногоон бонд

Ногоон эдийн засаг, ногоон шилжилтийн реформыг хэрэгжүүлэх хүрээнд



- Ногоон ирээдүй” бондыг дотоодын биржийн бус зах зээлд гаргалаа. Энэ нь Төрийн банкны анхны “Ногоон бонд” гэдгээрээ онцлог бөгөөд банкны тогтвортой хөгжлийн зорилт, тогтвортой санхүүжилтийг дэмжих ажлуудын эхлэл боллоо.



- Банк нь 2025 онд олон улсын зах зээлд ногоон бонд гарган тогтвортой санхүүжилтийн эх үүсвэр татахаар төлөвлөж, бэлтгэл ажлын хүрээнд 2024 онд банкны “Тогтвортой санхүүжилтийн хүрээ”-г Mitsubishi UFJ Financial Group (MUFG)-тэй хамтран тодорхойлж, боловсруулаад байна.



- Банкны “Тогтвортой санхүүжилтийн хүрээ” баримт бичигт 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдөр S&P Global байгууллагаар хөндлөнгийн үнэлгээ хийлгэв. Тус үнэлгээнд Төрийн банкны Тогтвортой санхүүжилтийн хүрээ нь олон улсын ногоон бонд, нийгмийн бонд, тогтвортой хөгжилтэй уялдсан бондын зарчим болон Ногоон зээл, нийгмийн зээлийн зарчмуудтай нийцсэн, сул тал илрээгүй гэж дүгнэсэн.

■ Зээлийн багц

ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛД ЧИГЛЭСЭН ЗЭЭЛ



₮178.0
тэрбум

▲ 92.86%
₮85.7 тэрбум



4,412
харилцагч

▲ 87.59%
2,060 харилцагч



5.09%
НИЙТ ЗЭЭЛД ЭЗЛЭХ ХУВЬ

▲ 1.29 нэгж хувь

НОГООН ЗЭЭЛ



₮53.6
тэрбум

▲ 108.57%
₮27.9 тэрбум



1,117
харилцагч

▲ 133.19%
638 харилцагч



1.53%
НИЙТ ЗЭЭЛД ЭЗЛЭХ ХУВЬ

▲ 0.47 нэгж хувь

■ Өөрийн эх үүсвэрийн санхүүжилттэй тогтвортой хөгжилд чиглэсэн бүтээгдэхүүн

Эко тээврийн хэрэгслийн зээл

- Эко тээврийн хэрэгслийн зээл нь иргэн, хуулийн этгээд өөрийн хэрэгцээнд зориулж банктай хамтран ажиллах гэрээтэй бэлтгэн нийлүүлэгчээс байгаль орчинд ээлтэй эко тээврийн хэрэгслийг худалдан авахад зориулагдсан зээл бөгөөд 2024 онд 374 зээлдэгчид 13.3 тэрбум төгрөгийн зээл олгосон.

Ахуйн хэрэглээний ногоон зээл

- Ахуйн хэрэглээний ногоон зээлийг иргэн, хуулийн этгээд өөрийн хэрэгцээндээ зориулж эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан бараа, сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж, бараа бүтээгдэхүүн, агаар хөрсний бохирдол бууруулах бараа бүтээгдэхүүн худалдан авахад зориулан олгодог бөгөөд 69 зээлдэгчид 452.0 сая төгрөгийн зээл олгосон.

Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны зээл

- Уг зээл нь эрчим хүчийг 20 хувиас дээш хэмнэж буй амины орон сууцыг худалдаж авах, барих, засварлахад зориулагдсан бөгөөд 2024 онд 168 зээлдэгчид 18.2 тэрбум төгрөгийн зээл олгосон байна.




Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих зээл

- Банк нь 2019 онд бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих зээлийг зах зээлд нэвтрүүлсэн нь бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн дунд хамгийн эрэлт хэрэгцээтэй бүтээгдэхүүн болсон бөгөөд 2024 онд 2,084 зээлдэгчид 107.0 тэрбум төгрөгийн зээл олгож, тэдний бизнесийн үйл ажиллагааг бодитоор дэмжин, ажлын байрыг нэмэгдүүлж, бизнесийн цар хүрээг нь тэлжээ.

Боловсролыг дэмжих зээл

- Боловсролыг дэмжих зээлийг сургуулийн өмнөх боловсрол болон ерөнхий боловсрол, дээд боловсрол зээмшихээр суралцаж буй иргэнд сургалтын төлбөр, дотуур байрны төлбөрөө төлөх, сургалтын хэрэглэгдэхүүн худалдаж авахад зориулж олгодог бөгөөд 2024 онд 38 зээлдэгчид 627.6 сая төгрөгийн зээл олгосон.



Өрхийн бизнесийн зээл

- Дундаж давхаргын иргэдийг дэмжих зорилгоор тодорхой хугацаанд бичил бизнес буюу жижиглэнгийн худалдаа, өрхийн аж ахуй, өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлсэн Улаанбаатар хотын болон орон нутгийн иргэдийг банкны бизнес инкубацийн үйлчилгээнд хамруулж, санхүүгийн зөвлөгөө мэдээлэл өгөх замаар бизнесээ амжилттай удирдахад нь дэмжлэг үзүүлсэн. Энэ хүрээнд өрхийн орлогоо нэмэгдүүлэхэд зориулан Өрхийн бизнесийн зээлийг 408 зээлдэгчид олгож, нийт 13.4 тэрбум төгрөгөөр санхүүжүүлсэн.

Гарааны бизнесийн зээл

- Дундаж давхаргыг дэмжих зорилгоор бизнес эрхлэгч иргэн, хуулийн этгээд болон гарааны бизнес эхлүүлэхээр зорьж буй иргэн, аж ахуйн нэгжийг банкны инкубацийн үйлчилгээнд хамруулан үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх, хөрөнгө оруулалт болон эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэхэд зориулж гарааны бизнесийн зээл олгодог. Тухайлбал, Улаанбаатар хот болон орон нутгийн бизнес эрхлэгч иргэн, хуулийн этгээдийг банкны инкубацийн үйлчилгээнд хамруулан бизнесийн болон санхүүгийн боловсрол, зөвлөгөө мэдээлэл өгөх, үйл ажиллагааны эхлэлийн болон өсөлтийн мөчлөгөөс тогтворжих түвшинд хүрэхэд нь дэмжлэг үзүүлэх, технологийн шинэчлэлт хийх, тоног төхөөрөмж худалдаж авах, шинэчлэх, үндсэн хөрөнгө болон эргэлтийн хөрөнгө бэлтгэх зэрэг үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зориулж, уг зээлийг олгож байна. Энэ хүрээнд 2024 онд нийт 305 зээлдэгчид 22.9 тэрбум төгрөгийн зээл олгосон.

■ Шинэ бүтээгдэхүүн



Малчны ногоон зээл

Мал аж ахуй, газар тариалан эрхлэгчдэд байгальд ээлтэй ногоон зээлийн бүтээгдэхүүнийг санал болгох зорилгын хүрээнд “Малчны ногоон зээл”-ийг 2024 оны 11 дүгээр сард зах зээлд нэвтрүүллээ. Тус бүтээгдэхүүн нь малын бэлчээрийн зүй зохистой ашиглалт,

малын ашиг шимийг нэмэгдүүлэх, малын тавлаг байдал, үүлдэр угсаа, эрүүл мэндийг сайжруулах зориулалтаар малчин иргэнд олгох зээл юм.



Оюуны хөрөнгө оруулалтын зээл

Дундаж давхаргын харилцагчдын санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор дотоодын их, дээд сургуульд суралцагчдад сургалтын төлбөр төлөхөд зориулж “Оюуны хөрөнгө оруулалтын зээл”-ийг 2024 оны 12 дугаар сард зах зээлд гаргалаа.

Тус зээлийн бүтээгдэхүүн нь оюутан суралцаж байх хугацаандаа зөвхөн зээлийн хүүг төлж, сургалтын хөтөлбөрөө төгссөнөөс хойш 6 хүртэлх сарын дараа үндсэн зээл, хүүгийн төлбөрийг хамтад нь төлөх нөхцөлтэйгөөрөө онцлог юм.



Ахуйн хэрэглээний цахим ногоон зээл


Дундаж давхаргын харилцагчдын санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, банкны үйл ажиллагаанд цахим шилжилтийг хэрэгжүүлэх болон байгаль орчин, нийгэм, засаглалд чиглэсэн үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгын хүрээнд “Ахуйн хэрэглээний цахим ногоон зээл”-ийн бүтээгдэхүүнийг

2024 оны 12 дугаар сард нэвтрүүллээ.

■ Тогтвортой хөгжилд чиглэсэн бусад бүтээгдэхүүн



“Эко боловсрол олгох аян”-ы хүрээнд Хүрээлэн төсөлтэй хамтран нэн ховор амьтдын зурагтай Эко картыг 2020 онд зах зээлд нэвтрүүлсэн бөгөөд нийт борлуулсан 106,211 карт тус бүрээс 1,000 төгрөгийг нэн ховордсон амьтдыг хамгаалах санд шилжүүлж байгаль, ан амьтдаа хамгаалахад хувь нэмэр оруулав.



Юнионпэй карт гаргагч байгууллагын Travel Mate Asia хөнгөлөлт урамшуулалд хамрагдах боломжтой, эмэгтэйчүүдэд зориулсан “Save green” кредит картыг Гялсбанк үйлчилгээгээр дамжуулж цахимаар авах боломжийг бүрдүүлэв. “Save green” кредит картыг 2024

онд нийт 657 харилцагчид 2.5 тэрбум төгрөгөөр борлуулсан байна.

21 аймгийн үзэсгэлэнт байгалийн зураг бүхий “Миний Монгол” олон улсын виза картыг 2021 оноос харилцагчдадаа санал болгож, нийт 26,488 карт олгоод байна.



Төрийн банк дундаж давхаргыг дэмжигч, үндэсний тэргүүлэгч банк байх зорилтын хүрээнд “Эрүүл амьдралын жигүүр” ТББ-тай хамтран ажиллах санамж бичгийг 2022 онд байгуулсан. Дундаж давхаргын иргэдэд хуримтлалын хэвшил бий болгох, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх

үзлэг шинжилгээнд гадаад, дотоодын гэрээт эмнэлгүүдэд хөнгөлөлттэй нөхцөлөөр хамрагдах боломжийг олгосон “Эрүүл иргэн” хугацаатай хадгаламжийн бүтээгдэхүүн, “Эрүүл иргэн” олон улсын виза картын бүтээгдэхүүнийг багцалсан “Эрүүл иргэн” багц бүтээгдэхүүнийг 2024 оны 12 дугаар сард гаргасан. 2024 оны байдлаар 5,587 хадгаламж, 5,374 карттай харилцагч байна. Эдгээр харилцагчид нь Төрийн банктай хамтран ажиллах гэрээтэй Монгол Улс дахь 12, БНСУ дахь 74, БНТУ дахь 2 нийт 88 эрүүл мэндийн байгууллагаар 10 хүртэлх хувийн хөнгөлөлттэй үнээр эрүүл мэндийн үйлчилгээ авах боломжтой юм.

■ Хамтран ажиллаж буй ногоон төсөл, хөтөлбөрүүд



Япон улсын Засгийн газар болон Монгол Улсын Сангийн яамтай хамтарсан “Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах 2 үе шаттай төслийн зээл” буюу JICA төслийн зээлийг байгаль орчныг хамгаалах, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих гэсэн хоёр үе шаттай олгодог. Энэхүү төсөл нь техник технологийн болон арилжаа, санхүүгийн хувьд найдвартай байх, эрүүл ахуй, аюулгүй байдал, нүүлгэн шилжүүлэлт, байгаль орчны болон удирдлагын стандартад нийцсэн байна. Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих 83 төслийн 39.9 тэрбум төгрөгийн зээл, байгаль орчныг хамгаалах 11 төслийн 5.9 тэрбум төгрөгийн зээл, нийт 94 төслийн 45.8 тэрбум төгрөгийн зээлийг 2006 оноос хойш санхүүжүүлээд байна.




БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ

Жилийн 9-13 хувийн хүүгийн татаастай “Байгальд ээлтэй хүүгийн хөнгөлөлттэй төсөл”-ийг БОУАӨЯ (Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам) –тай хамтран хэрэгжүүлж байна. Уг төслийн гол зорилго нь агаар, орчны бохирдлыг бууруулах зорилгоор цахилгаан халаагуур, дулаалгын материал, эко ариун цэврийн байгууламж, сайжруулсан зуух, сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж, цахилгаан тээврийн хэрэгсэл худалдан авах, хийн халаалтын төхөөрөмж худалдан авах, суурилуулах, нэвчилтгүй нүхэн жорлон, био жорлон худалдан авах болон суурилуулах, утаа шүүх яндан, яндангийн нэмэлт тоноглол, чип, дулаан шийдэл, ногоон амины орон сууц худалдан авах, бариулах зэрэг зориулалтаар зээл олгодог. “Байгальд ээлтэй хүүгийн хөнгөлөлттэй төсөл”-ийн хүрээнд 2020 оноос хойш 357 зээлдэгчид 5.5 тэрбум төгрөгийн зээл олгосон байна.



БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ

БОУАӨЯ-аас хэрэгжүүлж буй “Орчны бүсийн зээлийн эргэлтийн сангийн зээлийг дамжуулан зээлдүүлэх төсөл”-ийн хүрээнд Тусгай хамгаалалттай бүс нутгийн иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, өрхийн орлогыг нэмэгдүүлэх зээлийг Завхан, Өвөрхангай, Архангай, Хөвсгөл аймагт, Германы KfW байгууллагын санхүүжилтээр бэлчээрийн даацыг хэтрүүлэхгүй байх буюу малын тоо толгойг нэмэгдүүлэхгүй байх зорилго бүхий зээлийг Хэнтий, Дорнод, Архангай, Хөвсгөл аймгийн харилцагчдад санал болгож байна. Төслийн хүрээнд нийт 796 зээлдэгчид 7.0 тэрбум төгрөгийн зээл олгов.



ТоС Холбооноос НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран эрчим хүчний хэмнэлттэй монгол гэрийн дулаалга, халаалтын CHIP багцыг зорилтот бүлэгт өгөх хөнгөлөлттэй ногоон зээлийг хэрэгжүүлэхэд Төрийн банк хамтран ажиллаж байна.

■ Байгаль орчин, нийгэм, засаглалын эрсдэлийн үнэлгээ

Төрийн банк нь Монгол Улсын хууль тогтоомж, дотоод журам болон олон улсын нэгдсэн конвенцуудыг баримтлан зээл хүсэгчийн үндсэн болон санхүүжүүлэх үйл ажиллагаанд байгаль орчин, нийгэм, засаглалын анхан шатны болон нарийвчилсан үнэлгээг хийдэг. Ингэхдээ 100 сая төгрөгөөс дээш дүнтэй, 12 сараас дээш хугацаатай бизнесийн болон төслийн зээлийн хүсэлтэд эрсдэлийн үнэлгээг хийж байна.

Мөн зээлийн бодлогоор хориглох үйл ажиллагаа эрхэлдэг бизнесийг санхүүжүүлдэггүй, анхаарах шаардлагатай үйл ажиллагаа эрхэлдэг бизнесүүдэд эрсдэлийн үнэлгээ хийж, санхүүжилт олгох эсэхийг шийдвэрлэдэг. Эрсдэлийг удирдах боломжтой гэж үзсэн тохиолдолд зээл олгох, төслийг санхүүжүүлэх зарчмыг баримталж ажиллаж байна. Эрсдэлийн үнэлгээгээр өндөр болон дунд эрсдэлтэй үнэлэгдсэн зээлийн хувьд эрсдэл бууруулах боломж байгаа эсэхийг шалгаж, боломжтой тохиолдолд зөвлөмж өгч, хэрэгжилтэд нь зайнаас болон газар дээрх хяналт тавьж байна.

Зээл хүсэгчийн байгаль орчин, нийгэм, засаглалын эрсдэлийн үнэлгээ нь эрсдэлийг таних, хэмжих, үнэлэх, хянах, тайлагнах, бууруулах, удирдахад шаардлагатай банкны бодлого, журам болон тогтолцоог ногоон эдийн засагт шилжих үндэсний төлөвлөгөөтэй уялдуулан байгаль орчны холбогдох хууль тогтоомж, бодлого журамд нийцүүлэх бөгөөд үйл ажиллагаанаас учирч болох эрсдэлийг удирдаж байна.

2024
онд




239 харилцагчийн
98.0 тэрбум ₮ зээлд



БОНЗ-ын
эрсдэлийн
үнэлгээ
хийсэн.

БОНЗЭҮ хийсэн зээлийн багц, эдийн засгийн салбараар 2024



■ Уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэл

НҮБ-ын дэргэдэх "Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн түншлэл"-ийн дэмжлэгтэйгээр "Төв банкны ногоон болгоход бэлэн байдлын дэмжлэг үзүүлэх төсөл"-ийг Монголбанк 2023 оноос хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд уг төслийн зөвлөх багаар НҮБ-ын Ази-Номхон далайн бүсийн Эдийн засаг, нийгмийн комисс (UN Economic and Social Commission Asia and the Pacific) ажиллаж байна. Энэхүү төслийн хүрээнд банкны салбарын уур амьсгалын стресс тестийг туршилтаар системийн ач холбогдол бүхий банкуудын тоон мэдээлэлд үндэслэн анх удаа гүйцэтгэхээр төлөвлөсөн. Уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэл (ган зудын эрсдэл, үерийн эрсдэл, Парисын хэлэлцээрийн зорилттой нийцүүлэн дэлхийн дулаарлын 2°C дотор барихтай холбоотой 3 сценарь) нь банкны зээлийн эрсдэлд нөлөөлөх судалгаа, аргачлалын баримт бичгүүдийг боловсруулж банкуудад хүргүүлсэн. Уг аргачлалын дагуу Төрийн банк анх удаа уур амьсгалын өөрчлөлтийн сценарь шинжилгээг хийж гүйцэтгэв.

Түүнчлэн Төрийн банкны Эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичигт тогтвортой байдал, уур амьсгалын эрсдэлийн удирдлагын бүлгийг шинээр оруулж, ТУЗ-өөр батлуулсан бөгөөд бид энэ чиглэлд онцгойлон анхаарч уур амьсгалын эрсдэлийг тодорхойлох, сценарь шинжилгээг боловсруулах, ажилтнуудыг сургаж, чадавхжуулахад мэргэжлийн байгууллагаас зөвлөх үйлчилгээ авахаар төлөвлөж байна. Цаашид банк Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын S2 буюу уур амьсгалын өөрчлөлтийн стандартын дагуу тайлагнах боломжийг бүрдүүлэхээр ажиллаж байна.



■ Тайлагнал



Монгол Улсын Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс ногоон зээл, ногоон хөрөнгө оруулалтын шалгуур үзүүлэлт бүхий “Ногоон таксономи”-г 2019 онд баталсан бөгөөд банк тус 8 ангиллын дагуу ногоон зээлийн олголт, төлөлт, үлдэгдлийн мэдээг улирал бүр Монголбанканд тогтмол тайлагнаж байна.



Бид Тогтвортой санхүүжилтийн холбоонд хагас жил бүр сайн дурын үндсэн дээр Тогтвортой санхүүжилтийн хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлсэн ажлаа тогтмол тайлагнаж байна. Уг тайлангаар тогтвортой санхүүжилтийн менежментийн систем, байгаль орчин ба нийгмийн менежментийн систем, зээлд байгаль орчин нийгмийн эрсдэлийн үнэлгээ хийсэн байдал, ногоон зээл олгосон байдал болон ToC-ийн 8 зарчмын дагуу хийгдсэн ажлуудын хэрэгжилтийн мэдээллийг тайлагнадаг.



Төрийн банк олон нийтэд нээлттэй хувьцаат компани болсноор 2023 оноос эхлэн зохицуулагч байгууллагаас гаргасан удирдамжийн дагуу Байгаль орчин, нийгэм засаглалын тайланг Монголын хөрөнгийн биржэд 2 дахь жилдээ хүргүүлэв.



НҮБ-ын Даян дэлхийн гэрээний оролцогчийн хувьд банкны үйл ажиллагааг тогтвортой хөгжлийн зорилтуудад нийцүүлсэн байдал, ахиц дэвшлийн талаарх “Communication on Progress” тайланг анх удаа бэлтгэж хүргүүлээ.



☎ 1800-1881

🌐 www.statebank.mn

📘 /StatebankMN

📺 /StatebankMN



АВИЛГАТАЙ
ТЭМЦЭХ ГАЗАР

ШУДАРГА ЁС, ХӨГЖИЛ ДЭВШИЛД



Гомдол, мэдээлэл
хүлээн авах утас